



# JICA ALUMNI MONGOLIA

## ЖАЙКА-ын Сургалт Төгсөгчдийн Холбоо

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Бодь цамхаг, 7-р давхар, ЖАЙКА-ын Монгол дахь Төлөөлөгчийн Газар

Утас: 325 939, 311 329 И-мэйл: [jicamg-alumni@jica.go.jp](mailto:jicamg-alumni@jica.go.jp)

Цахим хаягууд: [www.jaam.mn](http://www.jaam.mn), <https://www.facebook.com/JICA Alumni Association Mongolia>

## Мэндчилгээ



**/ЖААМ-Н СТХ-НЫ  
ЕРӨНХИЙЛӨГЧ,  
МУ-Н ШАДАР САЙД АСАН  
Ц.ОЮУНБААТАР/**

Японы Засгийн Газрын хэрэгжүүлэгч агентлаг болох Японы Олон Улсын хамтын ажиллагааны байгууллага ЖАЙКА нь Японы засгийн газрын дэмжлэгтэйгээр монгол мэргэжилтнүүдийг урт болон богино хугацааны дадлага техникийн сургалт улмаар бакалавр, магистрын зэрэг олгох хүртэл сургалтуудыг тасралтгүй явуулсаар байна. Манай ЖАЙКА-н сургалт төгсөгчдийн монголын холбоо ЖААМ нь эдгээр сургалтанд хамрагдан төгсөгчдийн Японд сурч мэдсэн мэдлэг туршлагаа түгээн дэлгэрүүлэх, хоёр орны хоорондын найрсаг харилцааг улам бэхжүүлэх, техникийн болон бусад хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хамгийн гол нь Монгол орныхоо хөгжил дэвшилд хувь нэмэр оруулж бодитой үр дүн гаргахын төлөө дэмжин ажиллаж байгаа билээ. Энэ ч үүднээсээ Боловсрол, Эрүүл мэнд, Байгал орчин, Хөдөө аж ахуй, Татварын гэх мэт олон салбарт сургалт семинаруудыг амжилттай зохион байгуулж, тодорхой үр дүнд хүрсэн амжилт бүтээлээр дүүрэн шинэ оноо угтаж байна.

*Эрхэм төгсөгчид өө*

*Цаг хугацааны түүх болон үлдсэн хуучин оноо*

*Цаглашгүй их амжилт үйлсээр үдэж*

*Он цагийн тооллоор учран золгож байгаа шинэ жилээ*

*Од хийморь, орчлонгийн сайн сайн бүхнийг билэгдэн угтацгаая.*

### ЭНЭ ДУГААРТ

1. ЖААМ-ын Ерөнхийлөгч Ц.Оюунбаатарын шинэ жилийн мэндчилгээ
2. Газрын хөрсний дулаан солилцох системийг ашиглан өвлийн улиралд хүнсний ногоо тариалах
3. Камбожид түргэн тусламжийн эмнэлэг байгуулагдав.
4. АБЭ ИНИШИАТИБ.
5. “Алтайдаа хамтдаа хөгжье” семинар.
6. “Шинэ сувилагчийг дадлагажуулах нь” сэдэвт сургалт семинар.
7. Шинэ жилийн мэндчилгээ, ил захидал

## ГАЗРЫН ХӨРСНИЙ ДУЛААН СОЛИЛЦОХ СИСТЕМИЙГ АШИГЛАН ӨВЛИЙН ЦАГТ Ч НАРИЙН НОГООГ ТАРИАЛАХ БОЛОМЖТОЙ



ЖАЙКА олон улсын хамтын ажиллагааны байгууллагын “Өвсний үндэс” техникийн хамтын ажиллагааны төслийн хүрээнд “Газрын хөрсний дулаан /сэргээгдэх эрчим хүч/ солилцох системийг ашиглан хүнсний ногоог тариалах технологийг дэмжих” төслийг 2012 оноос эхлэн 4 жилийн хугацаанд амжилттай хэрэгжүүлж, төслийн баг хамт олон энэ жилийнхээ ургацаа хурааж хаалтын ажиллагаагаа хийлээ. Уг ажиллагаанд Японы Элчин Сайдын Яам, Жайка ОУХАБ, Эрчим Хүчний Яам бол Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газрын холбогдох төлөөлөгчид оролцсон байна.

Уг төслийн хүрээнд газрын хөрсний дулаан солилцох систем ба материал хангамж, үет ханатай пластик хоолойг “Секисүй Кемикал” ХК-н зөвлөх Ямабэ Ясүо, хүлэмжийг Хоккайдогийн Эрдэм Шинжилгээний Хүрээлэн, Цэцэг хүнсний ногооны технологийн төв-ийн ахлах судлаач Үбүката Масао, газрын хөрсний дулааныг ашиглан бага зардлаар ажиллах агааржуулалтын системийн талаар Хоккайдогийн Техникийн Их Сургуулийн Механик Инженерийн Сургуулийн Профессор Оотакэ Хидэо нар хариуцан ажилласан байна.

Уг технологи нь 5.5 метрийн газрын гүнд тусгай хоолойг байрлуулж газрын хөрсний дулааныг дамжуулан түүгээр хүлэмжийг дулаан агаараар хангах систем юм. Системийн онцлог нь энгийн бүтэцтэй, эвдрэл багатай тул удаан эдэлгээтэй, ашиглах хугацаа нь 50 жилээс дээш байх бөгөөд гарах зардал нь зөвхөн сэнсний цахилгааны зардал байдаг байна. Хүлэмжийн гаднах агаарын хэм -20оос -12 хэмтэй байх үед газрын гадаргаас дээш 5 см-г үзүүлэх дулаан нь +8-аас +20 хэм хүртэл байх боломжтой ба хүлэмжинд өргөст хэмх, улаан лооль, салатны навчнаас гадна Asparagus буюу хэрээн нүд, Spinach буюу бууцай гэх мэт нарийн ногоонуудыг тариалах боломжтой байдаг байна.



## КАМБОЖ УЛСАД ЯПОН МАЯГИЙН ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН ТӨВ “SUN RISE JAPAN HOSPITAL” БАЙГУУЛАГДАВ

### Эмнэлгийн өндөр ур чадвартай ажилтныг Японы болон дотоодын эмнэлэгтээ бэлтгэж байна



Эдийн засгийн хурдацтай хөгжлөөс үүдэн хүний амьдралын хэв маяг өөрчлөгдөж байна. Камбож зэрэг хөгжиж буй орнуудад ч амьдралын хэв маягаас үүдэлтэй өвчин болон зам тээврийн осол нэмэгдсний улмаас орчин үеийн өндөр технологи бүхий эмчилгээ үйлчилгээний хэрэгцээ шаардлага нэмэгдсээр байна.

Япон маягийн эмчилгээ үйлчилгээг бий болгосноор тухайн орны дотоод дахь эмчилгээ үйлчилгээний

түвшинг дээшлүүлэх зорилго бүхий энэхүү төсөл нь эмнэлгийн барилга байгууламж болон орчин үеийн эмнэлгийн тоног төхөөрөмжийг нийлүүлэхийн зэрэгцээ эмнэлгийн удирдлага, хүний нөөцийг дэмжиж байгаагаараа онцлогтой юм. SUN RISE JAPAN HOSPITAL PNOMPEN-ы нээлтээс өмнө өнгөрсөн жилээс өнөөг хүртэл 5-н удаагийн ээлжээр Камбожийн эмч сувилагч зэрэг эмнэлгийн ажилчдыг Токио хотын Китахара олон улсын эмнэлэгт урин дадлагажуулах сургалтыг зохион байгуулсан байна. ЖАЙКА-гийн хамтын ажиллагааны хүрээнд Японы эмнэлэгт хэрэглэгдэж буй тоног төхөөрөмжийг бодит байдал дээр хэрэглэн практик дадлагыг олгосон сургалт болсон.

Улмаар тухайн улсад хараахан хангалттайгаар нэвтрээгүй тархины мэс заслийн тасгийг тухайн эмнэлэгт бий болгож байна. Японы эмнэлгийн тоног төхөөрөмжийг нэвтрүүлэхийн хамт Япон эмч сувилагч нар бүрэн бүрэлдэхүүнээр ажиллана. Эдгээр эмч сувилагч нь Япон улсад мэргэжил дээшлүүлсэн эмнэлгийн ажилчидтай хамтран чанарын өндөр түвшинд эмчилгээ үйлчилгээг хүргэх болно.



## АБЭ ИНИШИАТИБ

“АБЭ Инициатиб” буюу япон улсын ерөнхий сайд Шинзо Абэ-ийн санаачилсан “АБЭ САНААЧЛАГА” хөтөлбөрийн хүрээнд Этиопын албан хаагч, ажилтануудыг мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулсаар байна. Японы томоохон компани, аж ахуйн нэгж байгууллагууд нь Африкийн орнуудад үйл ажиллагаагаа явуулж эхлээд байна. Үүнтэй уялдуулан ялангуяа Африк залуучууд, тэдний мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, хүний нөөцийг хөгжүүлэх зорилготой “АБЭ САНААЧЛАГА” төсөл хэрэгжиж байна. Уг төслийг хэрэгжүүлж буй гол байгууллага нь ОУХАБ болох ЖАЙКА юм. Уг хөтөлбөр нь магистрын зэрэг олгох сургалт болон мэргэжил дээшлүүлэх сургалт гэсэн програм бүхий хөтөлбөрийн дагуу 2014 оноос эхлэн 5 жилийн хугацаанд нийт 900 ажилтан, албан хаагчдыг мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулахаар төлөвлөсөн байна. Тэдний нэг болох Мога Богару нь 2015 оны 9 сараас эхлэн суралцаж

байна. Тэрээр Японы Технологийн Их Сургуульд онолын мэдлэгээ дээшлүүлэн суралцахын хажуугаар үнэт чулууны компанид дадлага хийж онол практикийг хослуулан мэдлэг ур чадвараа улам дээшлүүлж байна.



### ДАДЛАГАЖИГЧ ОЮУТАН МОГА БОГАРУ НЬ ЯПОНЫ “КАЙЗЭН”-Д СУРАЛЦАЖ БАЙНА

“АБЭ Инициатиб” хөтөлбөрийн хүрээнд Этиопын дадлагажигч оюутан Мога Богару нь энэ оны 9 сарын 15-наас эхлэн Токио хотын Ода дүүрэгт байрлах ОГУРА үнэт чулууны компанид дадлагажиж байна. ОГУРА үнэт чулууны компани нь дэлхий дээрх хамгийн хатуу чулуу болох очир эрдэнийн чулуу болох алмаз болон сафир, руби гэх мэт олон төрлийн үнэт чулуугаар ховор нарийн хийц бүхий үнэт эдлэл хийдэг нэр хүнд бүхий японы томоохон компануудын нэг юм. Мога Богару нь Этиопын Шинжлэх Ухаан Технологийн Яамны мэргэжилтэн бөгөөд Японы Шibaура Технологийн Их Сургуульд үйлдвэрлэлийн бүтээмж болон дизайныг сайжруулах, инженерчлэл сэдвээр судалгааны ажил хийж байна. Мога Богару бол ажилдаа маш махруу, технологийн нарийн уялдаа холбоог гүнзгий сонирхон судалдаг улмаар ийм тохиолдолд ямар болох вэ гэх мэт мэргэжлийн өндөр түвшний асуултуудыг тавьж аливаа асуудалд сэтгэлээрээ ханддаг, маш их зүйлийг сурч мэдмээр байгаа нь мэдрэгдэж байдаг гэж түүний

профессор багш нь үнэлсэн байна. Тэрээр эх орондоо буцаж очоод Японд сурч мэдсэн технологийн ур чадвар, арга барил ялангуяа ажиллах соёлыг түгээн дэлгэрүүлж, Этиоп Япон хоёр орныг холбох гүүр болон ажиллахыг зорилго болгоод Африкийн аж үйлдвэрийн хөгжил дэвшилд өөрийн гэсэн бодитой хувь нэмрээ оруулахыг хүсэж байна хэмээсэн байна.



## “ШИНЭ СУВИЛАГЧИЙГ ДАДЛАГАЖУУЛАХ НЬ” СЭДЭВТ СУРГАЛТ СЕМИНАР АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА.

(JICA Group Training Course of Nursing Management В) сургалтын төгсөгч Говь-Алтай аймгийн Нэгдсэн Эмнэлгийн Сувилахуйн Албаны арга зүйч Н.Цэвэлмаа МСН-ийн тэргүүн, УХТЭ-ийн Сувилахуйн Албаны дарга Д.Нямсүрэн нар

- Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага /ЖАЙКА/
- Монголын Сувилагчдын Нийгэмлэг
- Улсын хоёр дугаар төв эмнэлэгтэй хамтран 2016 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр ЭМЯ-ны хурлын “Б” танхимд амжилттай зохион байгууллаа.

Тус сургалтанд Нийслэлийн Эрүүл Мэндийн Газрын харьяа болон эрүүл мэндийн 27 байгууллагуудын 140 сувилагчдын төлөөлөл, сувилгааны албаны дарга, ахлах сувилагч, шинэ сувилагч нар оролцсон байна. Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн газрын дарга Я.Буянжаргал сургалтын үйл ажиллагааг нээж сургалтанд оролцогчдод хандан: “Сувилагч

мэргэжил бол үнэхээр бахархмаар мэргэжил” ШИНЭ СУВИЛАГЧИЙГ ДАДЛАГАЖУУЛАХ НЬ бидний тулгамдсан асуудал болоод байна гэдгийг тодотгон, сургалтын үйл ажиллагаанд амжилт хүслээ. Семинарын хүндэт зочноор Улсын Хоёрдугаар Төв Эмнэлгийн дарга Г.Баясгалан, ЖААМ-н ерөнхий нарийн бичгийн дарга Т.Золбоот, ЭМЯ-ны эмнэлгийн тусламжийн газрын мэргэжилтэн С.Алтанбагана нар оролцож монголын эрүүл мэндийн салбарт оруулж буй сувилагчдын хувь нэмэр цаашдын чиг хандлагын талаар үнэтэй санал зөвлөмжөө өглөө. Семинарт уригдсан бас нэгэн хүндэт зочин бол ЖАЙКА-н монгол дах төлөөлөгчийн газрын дарга ноён Сато Мүцүми байлаа. Тэрбээр “Эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжүүлж буй төслийн хэрэгцээ, үр дүн, цаашдын үйл ажиллагаа”-ны талаар танилцуулаад ЖАЙКА-н дэмжлэгтэйгээр японд сургалтад хамрагдаж ирсэн төгсөгчид маань япон дах сургалтаар олж авсан мэдлэг туршлагаа бусадтайгаа хуваалцаж ийнхүү сургалт семинаруудыг зохион байгуулж байдаг талархахын ялдамд цаашид





## ЖААМ ҮЙЛ АЖИЛЛАГАА

дэмжиж ажиллахад таатай байх тухайгаа илэрхийллээ. Энэхүү семинарт “Япон улсын сувилахуйн удирдлага менежмент”, “Шинэ сувилагчийг чиглүүлэх арга зүй”, “Сувилагч мэргэжилтний карьерын өсөлт”, “Шинэ сувилагчийг хөгжүүлэхэд сургагч багшийн үүрэг”-ийн талаар Монголын Сувилагчдын Нийгэмлэгийн тэргүүн Д.Нямсүрэн, “Японы сувилагчдын үйл ажиллагаа”, “Сувилгааны үнэлгээ хийх арга зүй”, “Сувилгааны багцын үнэлгээний карт үнэлж хөтлөх нь” сэдвээр Говь-Алтай аймгийн Сувилахуй албаны дарга, магистрант

Н.Цэвэлмаа нар илтгэл тавьж баг бүлгээр ажиллуулан, хэлэлцүүлэг зохион байгууллаа.

Сургалтанд оролцогчдоос цаашид энэхүү сургалтыг бусад эрүүл мэндийн байгууллагын сувилагч нарт тасралтгүй зохион байгуулах нь зүйтэй, хэрэгцээ шаардлагатай байна гэдэг саналыг дэвшүүлж байлаа. Мөн сургалтынхаа үйл ажиллагааг бусад сувилагч нартаа мэдээлэх зорилгоор хэвлэл мэдээлэл болон үндэсний телевизүүдээр товч мэдээлэл хүргэгдсэн байна.



## “АЛТАЙДАА ХАМТДАА ХӨГЖЬЕ” СЭДЭВТ СУРГАЛТ СЕМИНАР ЗОХИОН БАЙГУУЛАГДАВ

ЖАЙКА-н сургалт төгсөгчдийн холбооны гишүүн Говь-Алтай аймгийн 1-р сургуулийн багш С.Алтанзул, сургалтын менежер У.Энхтуяа нар хамтран 2016 оны 10 дугаар сарын 20, 21, 22-ны өдрүүдэд “Алтайдаа хамтдаа хөгжье” сэдэвт сургалт семинарыг орон нутагтаа амжилттай зохион байгууллаа. БСШУЯ-ны харьяа Говь-Алтай аймгийн үндэсний лаборатори

1-р сургууль нь 2011 оноос эхлэн сургалтын чанарын шинэчлэлийн цөм хөтөлбөр, 2014-2015 оны хичээлийн жилд бага боловсролын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлж, 2015-2016 оны хичээлийн жилд ахлах ангийн цөм хөтөлбөрийг туршин хэрэгжүүлж буй сургууль юм байна.



Холбооны гишүүн С.Алтанзулын зохион байгуулсан сургалтын зорилго нь Алтайн багш нарын заах арга зүйн технологи, мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх, чадваржуулахад туршлагаа түгээн дэлгэрүүлэх, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд чиглэгдсэн байна.

### Сургалтын үндсэн агуулга нь

- Сурагчдын хүсэл сонирхолд нийцсэн ээлжит болон нэгж хичээл бэлтгэх
- Сургалтыг идэвхижүүлэх аргууд
- Залуу багш нарын оролцоо, манлайлал
- Туршлагаа түгээн дэлгэрүүлэх

Уг сургалт семинар нь нийт 3 өдрийн турш явагдсан ба эхний өдөр Японы боловсролын системийн талаар болон Япон бага, дунд боловсролын байгалийн ухааны хичээлийн арга зүй /математик, физик, хими, биологи/ -н талаар багш С.Алтанзул, ээлжит хичээлийн хөтөлбөр боловсруулах, өдрийн сургалтын дүгнэлтийг сургалтын менежер У.Энхтуяа хөтлөн явуулж тухайн өдрийн сургалтын дүгнэлтээр өндөрлөлөө. Дараагийн өдрийн сургалт нь биологи, физикийн судалгаат хичээлийн дадлагын ажлыг багш С.Алтанзул эхлүүлж мэдээлэл хэсгийг багш У.Энхтуяа хөтлөн явууллаа. Семинарын сүүлийн өдөр сургалтыг идэвхжүүлэх арга

болон ЖАЙКА-н залуучуудын сургалтын талаар багш С.Алтанзул илтгэл тавьж, туршлага солилцох цагийг лаборатори сургуулийн сургагч багш нар удирдан явууллаа. Багшийн ажлын төлөвлөлтийн талаар багш У.Энхтуяа танилцуулж эцэст нь нэгдсэн дүгнэлт хийлээ.

С.Алтанзул багшийн зохион байгуулсан сургалт семинараас хүлээгдэж буй үр дүн нь багш хүүхэд бүрийн сонирхлын судалгааны үндсэн дээр хүүхдээр мэдлэг бүтээх арга зүйг хөгжүүлэх арга туршлага дээшлэнэ, хичээлийн судалгааг “нэгж хичээлийн хөтөлбөр боловсруулах”, “боловсруулсан хөтөлбөрөөр хичээл заах, ажиглалт хийх”, “хичээлийн дараах нэгдсэн хэлэлцүүлэг хийх” гэсэн гурван шатлалын дагуу амжилттай, идэвхитэй, санаачлагатай зохион байгуулах нь багш нар арга зүйгээ сайжруулах гол гарц болох бөгөөд хамтран суралцах, бусдаас суралцах, туршлага солилцох үйлийг хэрэгжүүлэх туршлага хуримтлуулж, бусад багш нартайгаа хамтран ажиллах ажлын төлөвлөлттэй болно. Мөн сургуулийн удирдлагын төлөвлөгөө, эрчимжүүлсэн сургалтыг сайжруулах, байгалийн ухааны сургалтын материалын ашиглалтыг дэмжих, залуу багш ажлын байран дээр хөгжих арга барил эзэмших, дадлагажих, чадваржих замаар хөгжнө гэж үзсэн байна.



ЭРХЭМ ТӨГСӨГЧИД ӨӨ  
ШИНЭ ЖИЛИЙН БАЯРЫН МЭНД ХҮРГЬЕ



謹  
賀  
新  
年

Н  
А  
Р  
Р  
У

Н  
Э  
В

У  
Э  
А  
Р

